



## СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 15 сарын 10 өдөр


Дугаар 1/10

Улаанбаатар хот

### Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь заалт, Стандарт, хэмжил зүйн газрын даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын шалгагчийн үнэмлэх, тэмдэг болон хэмжих хэрэгслийн улсын баталгааны лац, тэмдэг хэрэглэх журмыг нэгдүгээр, Улсын шалгагчийн үнэмлэхийн загварыг хоёрдугаар, Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын лабораторийн тэмдгийн загварыг гуравдугаар, Улсын шалгагчийн тэмдгийн загварыг дөрөвдүгээр, хэмжих хэрэгслийн улсын баталгааны лац, тэмдгийн загварыг тавдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын газар /Л.Баярхүү/, Хэмжил зүйн хүрээлэн /Д.Дамбасүрэн/, аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга наарт, журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлт, дотоод аудитын газар /Б.Уганбаяр/-т тус тус даалгасугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2011 оны А/264 дүгээр тушаал, 2013 оны А/53 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



028028889

Стандарт, хэмжил зүйн газрын дэргийн  
2021 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн  
110 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

## УЛСЫН ШАЛГАГЧИЙН ҮНЭМЛЭХ, ТЭМДЭГ БОЛОН ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН УЛСЫН БАТАЛГААНЫ ЛАЦ, ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хэмжил зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах улсын шалгагчийн үнэмлэх, тэмдэг болон хэмжих хэрэгслийн улсын баталгааны лац, тэмдэг (цаашид "үнэмлэх, тэмдэг, баталгааны лац, тэмдэг" гэх)-тэй холбоотой харилцаа (захиалах, хүлээн авах, олгох, хэрэглэх, хадгалах, хураан авах, устгах, хяналт тавих, хариуцлага тооцох)-г энэ журмаар зохицуулна.

1.2 Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийн төрөл, загвар, хэмжээ, материалын тодорхойлолтыг Хэмжил зүйн төв байгууллага батална.

1.3 Хэмжих хэрэгслийн баталгааны лац, тэмдэг, түүнийг хадгалах хайрцаг, сав нь OIMLR42 "Улсын шалгагчийн металл тэмдэг" Хууль зэхийн хэмжил зүйн олон улсын байгууллагын зөвлөмжийн шаардлагыг хангасан байна.

1.4 Улсын шалгагч нь Хэмжил зүйн төв байгууллагаас олгосон хувийн дугаартай үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг хэрэглэнэ.

1.5 Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийн хувийн дугаар ижил байх бөгөөд улсын шалгагчдын хувийн дугаарууд нь өөр хоорондоо давхардахгүй байна.

1.6 Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдэг нь Хэмжил зүйн төв байгууллагын өмч байна.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1 "Улсын шалгагчийн тэмдэг" гэж энэ журмын 5.4-т заасан баримт бичгүүдэд дарах тэмдгийг:

2.1.2 "Хэмжих хэрэгслийн улсын баталгааны тэмдэг" гэж Шалгалт баталгаажуулалтад тэнцсэн хэмжих хэрэгслийг битүүмжлэн дарах лац, тэмдгийг:

Гурав. Үнэмлэх, тэмдэг болон баталгааны  
лац, тэмдэг захиалах

3.1 Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага болон хэмжил зүйн мэргэжлийн байгууллагуудын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн үнэмлэх, тэмдэг болон

баталгааны лац, тэмдгийг батлагдсан загвар, дугаарын дагуу захиалах ажлыг Хэмжил зүйн төв байгууллага хариуцна.

3.2 Хэмжил зүйн төв байгууллага нь тухайн онд хэрэглэх хэмжих хэрэгслийн баталгааны лац, тэмдгийг өмнөх оны 01 дүгээр сард багтаан захиалсан байна.

3.3 Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг хийлгэх, баталгааны лац, тэмдгийг хадгалах хайрцаг, сав худалдан авах зардлыг Хэмжил зүйн төв байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

3.4 Хэмжил зүйн төв байгууллага нь Хэмжил зүйн бодлого хариуцсан нэгжийн захиалгаар баталгааны лац, тэмдгийг үйлдвэрлэх эрх бүхий байгууллагатай гэрээ хийсний үндсэн дээр захиална. Гэрээнд лац, тэмдгийн нууцлал алдагдахаас сэргийлэх талаар тусгана.

#### **Дөрөв. Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг хүлээн авах, олгох**

4.1 Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг захиалгын дагуу хийгдсэн эсэхийг санхүү, бүртгэлийн ажилтан шалган хүлээн авч, байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн, Хэмжил зүйн бодлогын асуудал хариуцсан нэгжийн даргад акт үйлдэж хүлээлгэн өгнө.

4.2 Хэмжил зүйн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга хэмжих хэрэгслийн баталгааны лац, тэмдгийг тухайн оны 01 дүгээр сард багтаан улсын шалгагч наарт олгож, дараа оны 01 дүгээр сард хураан авах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.3 Улсын шалгагчийн эрх олгосон, цуцалсан, ажлаас чөлөөлсөн тухай Хэмжил зүйн төв байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн Хэмжил зүйн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга улсын шалгагчид үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг олгож, хураан авна.

4.4 Баталгааны лац, тэмдэг олгосон, хураан авсан баталгааны лац, тэмдгийн дардсын бүртгэлийг Хэмжил зүйн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга хөтөлнө.

#### **Тав. Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг хэрэглэх, хадгалах**

5.1 Улсын шалгагч албан байгууллага, иргэд, үйлчлүүлэгчдэд үнэмлэхээ үзүүлж, хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

5.2 Улсын шалгагч үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг зөвхөн хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх үед хэрэглэх бөгөөд зориулалтын дагуу хэрэглэж хадгалалт, хамгаалалтыг бүрэн хариуцна.

5.3 Улсын шалгагчийн үнэмлэхийг цэвэр, нямбай ашиглаж хүчинтэй хугацааг жил бүр Хэмжил зүйн төв байгууллагын даргаар баталгаажуулна.

5.4 Улсын шалгагчийн тэмдгийг дараах албан ёсны баримт бичгийг баталгаажуулах зорилгоор хэрэглэнэ. Үүнд:

- 5.4.1 Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ
- 5.4.2 Хэмжих хэрэгсэл улсын баталгаажуулалтад тэнцээгүй тухай мэдэгдэл
- 5.4.3 Улсын шалгагчаас илрүүлсэн зөрчлийн тухай тэмдэглэл
- 5.4.4 Хэмжих хэрэгслийн шалгалтын тайлан (шалгалтын протокол)
- 5.4.5 Баталгаажуулалт хийсэн тухай тэмдэглэл
- 5.4.6 Хэмжих хэрэгслийн ашиглалтын баримт бичиг

5.5 Улсын шалгагчийн тэмдгийг энэ журмын 5.4-т заасан баримт бичгийг баталгаажуулах зорилгоор улсын шалгагч өөрийн гарын үсгэн дээр тод, гаргацтай дарна.

5.6 Энэ журмын 5.4-т зааснаас бусад баримт бичгийг баталгаажуулах зорилгоор улсын шалгагчийн тэмдэг хэрэглэхийг хориглоно.

5.7 Шалгах аргын улсын стандарт, аргачлалын шаардлага хангасан хэмжих хэрэгслийн заалтыг өөрчлөх, дахин тохируулах, эд ангиудыг салгах зэрэгээс сэргийлсэн битүүмжлэлийн цэгүүдэд шинээр баталгааны лац, тэмдгийг улсын шалгагч өөрөө тод, гаргацтай дарах буюу наана.

5.8 Улсын шалгагч зөвхөн тухайн хэмжлийн төрөлд хамаарах хэмжих хэрэгсэлд баталгааны лац, тэмдгийг, шалгалт баталгаажуулалтын гэрчилгээн дээр тэмдэг дарж баталгаажуулна.

5.9 Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг барьцаалах, хаяж үрэгдүүлэх, загварыг өөрчлөх, хуурамчаар үйлдэх, зохих зөвшөөрөлгүйгээр дур мэдэн бусдад шилжүүлэх, ашиглуулах, хадгалуулахыг хориглоно.

5.10 Хаяж үрэгдүүлсэн (алдагдсан), баталгааны лац, тэмдэгт хамаарах хугацаа дууссан, гэмтэлтэй буюу анхны дардаснаас зөрүүтэй, хүчингүй болсонд тооцсон баталгааны лац, тэмдэг хэрэглэхийг хориглоно.

5.11 Улсын шалгагч үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгээ хаяж үрэгдүүлбэл ажлын 3 хоногийн дотор харьяалах нэгжийн дарга болон цагдаагийн байгууллагад мэдэгдэн, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлуулж, хүчингүй болгуулах арга хэмжээ авна.

**Зургаа. Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац,  
тэмдгийг хураан авах, буцаан олгох, устгах**

6.1 Улсын шалгагч дараах тохиолдолд үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгээ Хэмжил зүйн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга болон эрх бүхий нэгжийн даргад бүртгэлээр хулээлгэн өгч, буцаан авна.

- 6.1.1 Ээлжийн амралт авах;
- 6.1.2 Сэлгэн ажиллах;
- 6.1.3 Ажлын 10 хоногоос дээш хугацаагаар өвчтэй байх, чөлөө авах;
- 6.1.4 Өөр хэмжлийн төрлөөр эрх авах;

6.2 Дараах тохиолдолд баталгааны лац, тэмдгийг олгосон үеийн дардастай нь тулган Хэмжил зүйн бодлого хариуцсан нэгжийн дарга хурааж авна. Үүнд:

- 6.2.1 Улсын шалгагчийн эрх цуцлагдсан
- 6.2.2 Ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, шилжсэн
- 6.2.3 Нас барсан
- 6.2.4 Баталгааны лац, тэмдэгт хамаарах хугацаа дууссан
- 6.2.5 Баталгааны лац, тэмдэг гэмтэлтэй буюу дардас нь анхны загвараас зөрүүтэй
- 6.2.6 Хүчингүй болсонд тооцсон баталгааны лац, тэмдэг олдсон

6.3. Энэ журмын 6.2.1-6.2.3 -д заасан нөхцөл байдал үүссэн бол улсын шалгагчийн үнэмлэх, тэмдгийг мөн хураан авна.

6.4 Энэ журмын 6.2-д заасан шалтгаанаар үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгээ хураалгаагүйн улмаас байгууллагад хохирол учирсан тохиолдолд эрх бүхий байгууллагад хандан улсын шалгагчийн үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг албадан гаргуулна.

6.5 Хаяж үрэгдүүлсэн (алдагдсан) үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг дахин олгох асуудлыг Хэмжил зүйн төв байгууллага шийдвэрлэнэ. Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг дахин олгоход дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

6.5.1 Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг олгохыг хүссэн улсын шалгагчийн өргөдөл, харьяалах нэгжийн даргын тодорхойлолт, албан бичиг.

6.5.2 Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг хүчингүй болгосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулсан баримт.

6.5.3 Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийн үнийг төлсөн баримт.

6.6 Хураан авсан баталгааны лац, тэмдгийг Хэмжил зүйн бодлого хариуцсан нэгжээс олгосон, хураан авсан бүртгэлийн хамт Хэмжил зүйн төв байгууллагын архивт хүлээлгэн өгөх бөгөөд Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар томилсон ажлын хэсэг холбогдох дүрэм, журамд заасан хугацааны дараа устгаж, акт үйлдэнэ. Устгалын актыг үндэслэн баталгааны тэмдгийг байгууллагын үндсэн хөрөнгийн данснаас хасна.

**Долоо. Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац,  
тэмдгийн хадгалалт, ашиглалтад хяналт тавих**

7.1 Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалт хариуцсан нэгжийн дарга болон аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга баталгааны лац, тэмдгийн ашиглалт, хадгалалтад хяналт тавина.

## **Найм. Хүлээлгэх хариуцлага**

**8.1** Үнэмлэх, тэмдэг болон баталгааны лац, тэмдгийг хаяж үрэгдүүлсэн бол буруутай этгээдээр үнэлгээг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр нөхөн төлүүлнэ.

**8.2** Энэ журмыг зөрчсөн албан хаагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ. Улсын шалгагч энэ журмын 5.4, 5.6, 5.8, 5.9, 5.10-т заасныг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан эрх бүхий албан тушаалтан хариуцлага ногдуулах бөгөөд Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар улсын шалгагчийн эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

**8.3** Улсын шалгагчийн эрхийг сэргээх асуудлыг Хэмжил зүйн бодлогын асуудал хариуцсан нэгжийн даргын саналыг үндэслэн Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

**8.4** Энэ журмыг зөрчсөн улсын шалгагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулна.

----- о О о -----